

Сангийн сайдын 2013 оны 05 дугаар
сарын 31-ний өдрийн 125 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

**ҮНИЙН САНАЛ АВАХ
ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.
**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар
2013 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтад бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК

Огноо: 2020.03.13

**[/ТАНИХ ТЭМДЭГ, ШАТ, ГУРВАЛЖИН ШОН, ПЛАКАТУУД,
АНХНЫ ТУСЛАМЖИЙН АПТЕК, САМБАР БУСАД ХЭРЭГСЛҮҮД/
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН
САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: *Таних тэмдэг, шат, гурвалжин шон, плакатууд, анхны тусламжийн аптек, самбар бусад хэрэгслүүд.*

Төслийн дугаар: ХАБЭА-2020/9

Харьцуулалт/
гэрээний дугаар: ХАБЭА-2020/9

Улаанбаатар хот

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Таних тэмдэг, шат, гурвалжин шон, плакатууд, анхны тусламжийн аптека, самбар бусад хэрэгслүүд]**–ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 03-р сарын 27-ны өдрийн 15 цаг 00 минутаас]**-аас өмнө [\[www.tender.gov.mn\]](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 03-р сарын 27]**-ны өдрийн **[15 цаг 30 минут]**¹-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх.² Үгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж,
“Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, Өргөтгөлийн 3 давхар байрны
1 давхрын 100 тоот өрөө Утас: 75753047-242, 238 Факс: +976-11-342397.]**

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

² Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн бол нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн [1] /2019/ жилийн санхүүгийн тайлан ирүүлэх - Сүүлийн / 2018, 2019/ 2-н жилийн аль нэгэнд нь хийж гүйцэтгэсэн ажлын /гэрээ, гэрээ дүгнэсэн актыг/ ирүүлэх багаж хэрэгсэл нийлүүлж байсан ажлын сайн туршлагатай байх. - Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 50% хувиас багагүй байна. <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ul style="list-style-type: none"> - Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ - Компанийн танилцуулга - Татварын тодорхойлолт ирүүлэх /Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Цахим системээр шалгана./ - Нийлүүлэх барааны фото зургийг ирүүлнэ. /Тендерийн хэл нь Монгол хэл тул гадаад хэл дээрх аливаа материалыг баталгаат орчуулгаар Монгол хэл рүү орчуулсан байна./
ТӨӨЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: “Таних тэмдэг, шат, гурвалжин шон, плакатууд, анхны тусламжийн аптека, самбар бусад хэрэгслүүд” нийлүүлэх ХАБЭА-2020/09
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, Утас: 75753047-242, 238 Факс: +976-11-342397.] www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ. Давхар болон өрөөний дугаар: [Өргөтгөлийн 3 давхар байр 100 тоот өрөө]</p> <p>Огноо: [2020 оны 03 дугаар сарын 27-ны өдөр] Цаг: [15 цаг 00 минут]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, Утас: 75753047-242, 238 Факс: +976-11-342397.] Давхар болон өрөөний дугаар: [Өргөтгөлийн 3 давхар байр 100 тоот өрөө]</p> <p>Огноо: [2020 оны 03 дугаар сарын 27-ны өдөр] Цаг: [15 цаг 30 минут]</p>
ТӨӨЗ 3.1 а	Тендерийн жишиг маягтын дагуу техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн үнийн санал ирүүлэх
ТӨӨЗ 3.1 д	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтонд заасан шаардлагуудыг хангасан байх тодорхойлолт баталгаажуулж ирүүлэх
ТӨӨЗ 3.1 д	<ol style="list-style-type: none"> 1. Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт ирүүлэх 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт ирүүлэх
ТӨӨЗ 3.1 д	Бараа хүргэх эцсийн цэг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байрны агуулах
ТӨӨЗ 6.1 д	Үнийн санал нь тендер ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. /Албан мэдэгдэлд баталгаажуулж ирүүлэх/

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ Барааны тодорхойлолт:**
 [Барааны тодорхойлолтыг доорх хүснэгтээр оруулав.]





Б. БАТБАЯР


БАТЛАВ: "УБДС" ТӨХК-Н ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


2020 онд "УБДС" ХК-ийн ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангахад олгох барааны тодорхойлолт

№	Аюулгүй ажиллагааг хангах барааны нэрс	Хэмжих нэгж	Тоо	Нийтлэг тавигдах шаардлагууд	Бараа тус бүрт анхаарах зүйлс	Барааг нийлүүлэх хугацаа
1	Хүндрүүлэгчтэй таних тэмдэг	ш	27	Стандартын шаардлага хангасан байх	Стандарт хэмжээтэй, фосфортод. Саадыг тойрч гарах тэмдэг 2 талдаа, Ажил хийж байна тэмдэг. Орохыг хориглоно тэмдэг.	Гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор
2	Хөндлөвчтэй гурвалжин шон	ш	30	Стандартын шаардлага хангасан байх	Шонгийн өндөр h=69см. Хүндрүүлэгчтэй, материалын гадаргуу хатуу бат бөх, дээрээ гэрэлтүүлэг зоодог байх. Фосфортод гурээтэй байх.	
3	Гурвалжин шон	ш	20	Стандартын шаардлага хангасан байх	Шонгийн өндөр h=69см. Хүндрүүлэгчгүй, хөнгөн жинтэй, материалын гадаргуу хатуу бат бөх, дээрээ гэрэлтүүлэг зоодог байх. Фосфортод гурээтэй байх.	



4	Зөөврийн сунадаг А шат /8м-тэй/	ш	11	Стандартын шаардлага хангасан байх	Зөөврийн 3м-ийн хэмжээтэй А хэлбэрийн, сунадаг шат байна. Бат бөх эдэлгээ даах, 200кг хүртэл ачаа даах чадвартай байх.	
5	Япон шат	ш	5	Стандартын шаардлага хангасан байх	Дээрээ 2 салдаг тавцантай, дээш нь сунгаж угсрах боломжтой, хамгаалалтын түгжээтэй байх.	
6	Цоож пайзны систем	ш	30	Стандартын шаардлага хангасан байх	Бүх төрлийн хуваарилах байгууламжийн хоригийн түгжээнд таардаг цоожтой, ажилтаны цээж зураг хувийн мэдээлэл, утасны дугаарыг багтаасан хүснэгттэй байна.	
7	Өвдгөвч, тохойвч хос	ш	30	Стандартын шаардлага хангасан байх	Ажил хийхэд тохиромжтой, бэхлэлт түгжээ сайн эдэлгээ даах бат бөх байх.	

8	Гурвалжин шонгийн шөнийн гэрэл	ш	10	Стандартын шаардлага хангасан байх	Нарны эрчим хүчээр цэнэглэдэг, цэнэгээ удаан барьдаг. Гурвалжин шонд сурилуулдаг. Улаан ба шар өнгөтэй байх.	
9	ХАБЭА н самбар	ш	50	Стандартын шаардлага хангасан байх	Самбарын загвар, хэмжээ, материал тохирно. 1 ш самбар 1.5 м2-аас багагүй хэмжээтэй. PVC материалаар хийгдсэн байна.	
10	Хориглох, анхааруулах, сануулах плакатууд, тэмдэглэгээ	ш	45	Стандартын шаардлага хангасан байх	Аюулгүй ажиллааны дүрэмд заасан хэмжээ шаардлагыг хангасан байх. Цэхилгаан дамжуулдаггүй материалаар хийгдсэн байна. /хатуу PVC/	
11	Хамгаалалтын тууз /Солонгос/	ш	12	Стандартын шаардлага хангасан байх	Дээрээ бичиглэлтэй, Бат бөх, зузаан, амархан сунаж, тасардаггүй байх.	
12	Аврах гарцын тэмдэглэгээ	ш	50	Стандартын шаардлага хангасан байх	Уян гадаргатай фосфортодго гарцын тэмдэг, 14смх36см	
13	Галын хоолойн байршлын тэмдэглэгээ	ш	80	Стандартын шаардлага хангасан байх	7см х 10см А-7 нимгэн хөөс, наалддаг	
14	Гал унтраагуурын байршлын тэмдэглэгээ	ш	80	Стандартын шаардлага хангасан байх	7см х 10см А-7 нимгэн хөөс, наалддаг	

15	Ухсан сувгийг нурахаас хамгаалах бэрээнт	ш	50	Стандартын шаардлага хангасан байх	Бат бөх эдэлгээ даах, зузаан, ус, чийгэнд тэсвэртэй байх. /Орос бэрээнтэн материалтай дүйцэхүйц 1.8м өргөнтэй байна/	
16	Өмсгөлтэй хамгаалалтын бүс	ш	30	Стандартын шаардлага хангасан байх	Өвлийн ажлын хувцсан дээр өмсөж ажиллаж болохоор том размертэй байх. Бат бөх эдэлгээ даах, 200кг хүртэл ачаа даах чадвартай байх. /2м-тэй, том размер/	
17	Анхны тусламжын аптек	ш	27	Стандартын шаардлага хангасан байх	Аспирин, парацетамол, диклофенк зэрэг халуун бууруулж, өвчин намдаах эмүүд, гэдэсний эм, шархны тос, ханиадны эм, гуурсан хоолойн тэлэх эмийн бэлдмэл, шархны төрөл бүрийн боолт /9см уян бинт/, шархны лент, ариутгалын уусмал /спирт, иод, тамедин/, самбай хөвөн, жижиг хайч, чимхүүр, халууны шил, гар чийдэн, нэг удаагийн бээлий	
18	ХАБЭА-н тавиур	ш	10	Стандартын шаардлага хангасан байх	Өргөн 80см өндөр 150см зузаан 30см хэмжээтэй 2 эгнээ тавиуртай тавиур хоорондын зай 40см дээрээ 10 ширхэг өлгүүртэй төмөр материалаар хийгдсэн байх.Хуваарилах байгууламжийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл аюулгүй ажиллагааны плакат, багаж хэрэгсэл байрлуулах зориулалттай байна.	

Техникийн тодорхойлолт гаргасан: ХАБЭАХБИ

Б.Баярмаа



- 1. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Барааны техникийн тодорхойлолт заасан шаардлагуудыг хангасан байна.
- 2. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Барааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
- 3. Бараа хүргэх газар:** [Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байрны агуулах]
- 4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Хүндрүүлэгчтэй таних тэмдэг	Техникийн тодорхойлолт онд дэлгэрэнгүй заасан /Стандартын шаардлага хангасан байх/	27	ш	УБДС ТӨХК төв байрны агуулах	Гэрээ байгуулагдс наас хойш 5 хоног	Гэрээ байгуулагдснаас хойш 10 хоног	
Хөндлөвчтэй гурвалжин шон		30	ш				
Гурвалжин шон		20	ш				
Зөөврийн сунадаг А шат /8м-тэй/		11	ш				
Япон шат		5	ш				
Цоож пайзны систем		30	ш				
Өвдөгвч, тохойвч хос		30	ш				
Гурвалжин шонгийн шөнийн гэрэл		10	ш				
ХАБЭА-н самбар /1,5м2-с багагүй/		50	ш				
Хориглох, анхааруулах, сануулах плакатууд, тэмдэглэгээ /хутуу рvc/		45	ш				
Хамгаалалтын тууз /Солонгос/		12	ш				
Аврах гарцын тэмдэглэгээ		50	ш				
Галын хоолойн байршлын тэмдэглэгээ		80	ш				
Гал унтраагуурын байршлын тэмдэглэгээ	80	ш					

Ухсан сувгийг нурахаас хамгаалах бэрзэнт /1.8м өргөнтэй/		50	ш				
Өмсгөлтэй хамгаалалтын бүс /2м-тэй, том размер/		30	ш				
Анхны тусламжын аптек		27	ш				
ХАБЭА-н тавиур		10	ш				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ний
гүйцэтгэх захирал Г.Баярсайхан танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-ээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |

**11. Маргааныг
шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. Захиалагчаас томилсон комисс өөрийн байранд Нийлүүлэгдсэн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг акт үйлдэж хүлээн авна.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 4) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
[1 жил байна.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)³
- 9.1. Алданги оногдуулах хувь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутам : **[0,5%]**
- Алдангийн нийт дүн: **[10 хувь]**

³ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[..... **АЖЛЫН**] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [**захиалагчийн нэр**] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [**нийлүүлэгчийн нэр**] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [**гэрээний үнийг тоогоор болон үсгээр**] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-аас _____ оны __ дугаар сарын __-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁵;
Үнийн санал;

⁴ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁵ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]